



INCLUSION POLICY

DATE DOCUMENT PUBLISHED: **APRIL 2022**

APPROVAL BY: **HEAD OF SCHOOL**

APPROVAL DATE: **APRIL 2022**

DOCUMENT OWNER: **HEAD OF SCHOOL AND IB COORDINATOR**

DATE FOR REVIEW: **MAY 2023**

REVIEWER: **IRMUUN BAYASGALAN**

ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО

Олонлог академи нь өөрийн философи, үнэт зүйл, итгэл үнэмшлийн дагуу манайд суралцах хүсэлтэй хүүхэд нэг бүрийг дэмжих бодлого баримтална. Сургалтын орчныг хүн бүрд ээлтэй байхаар бүрдүүлж, шаардлагатай үед боломжит нэмэлт өөрчлөлтүүдийг хийнэ. Цаашид тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан суралцах орчин нөхцөлийг сайжруулах бодлого барьж ажиллана.

Элсэлтийн бодлого ба тэгш хүртээмжтэй боловсрол олгох бодлого

Олонлог академид элсэн суралцах хүүхэд бүрийг сурах боломжоор хангахын тулд элсэлтийн үеэр эцэг эхээс дэлгэрэнгүй судалгаа, хүүхдүүдээс түвшин тогтоох шалгалт авдаг бөгөөд эдгээрээс хүүхэд нэг бүрийн суралцах үйл явцад тулгарч болзошгүй саадыг тодорхойлж, сургуулийн орчныг бэлтгэх, эцэг этэй хамтран ажиллах, нэмэлт сургалт, хөтөлбөр, тохижилт, тоноглол байрлуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

INCLUSION POLICY

Olonlog Academy has a policy of supporting every child who wants to study at our school under its philosophy, values and beliefs. We strive to create a learning environment that is friendly to everyone and make possible adjustments as needed. In the future, we will pursue a policy to improve the learning environment for children with special needs.

Admission policy in regards to inclusion policy

In order to ensure that every child enrolled at Olonlog Academy has the opportunity to study at our school, parents/guardians are required to conduct a detailed survey. On the other hand, placement test is taken at the time of enrollment to identify potential barriers to each child's learning and thus prepare the school environment, provide an additional training program, landscaping and equipment placement. Also, collaborative work with parents and guardians is essential for special need students.

